

**Сум, аймаг, бүс, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцсон оролцоо, амжилт, шагнал урамшил, санхүүжилт үр дүн:**



Соёлын төв нь албан байгууллага иргэдийнхээ дунд Засаг даргын ивээл дор зохион байгуулах “Авьяаслаг Өндөршилчүүд “ урлагийн бага наадмыг зохион байгуулав. Урлагийн 9 төрөлд ур чадвараа сорьж аваргуудыг тодруулан алдаршуулсан. Тус үйл ажиллагааны шагнал урамшлын зардалд Засаг даргын нөөц сангаас-270 000 мянган төгрөг, соёлын төв уран бүтээлийн сангаас – 258 000 мянган төгрөг, орлогоос -258 000 мянган төгрөг гарган нийт зардал-786 000 мянган төгрөгийг зарцуулсан. Урлагийн бага наадамд нийт 76 авьяастан оролцож СББӨ-ийг өвлөн уламжлагч шинээр 27 тодруулан алдаршуулж, соёл урлагийн өдөрлөгт оролцох урилга олгов.

Дуу хуур - бидний өв үзэсгэлэн гаргаснаар иргэдээс 140 төрлийн 262 ш соёлын үнэт үзмэр, гар урлал, угсаатны зүй, хүрэл чулуун зэвсгийн үзмэрүүд дэлгэгдэж сурталчилагдаж үзэгч олны хүлээсэн ажиллагаа болсон.

Тус уралдаан нь байгууллага хамт олноороо нь шалгаруулахад 1-р байрыг Хүүхдийн цэцэрлэг, 2-р байрыг ЗДТГ, 3-р байрыг Дунд сургуулийн хамт олон тус тус эхний байрыг тус тус эзэлсэн.



Дуу хуур -бидний өв үзэсгэлэн гаргаснаар иргэдээс 140 төрлийн 262 ш соёлын үнэт үзмэр, гар урлал, угсаатны зүй, хүрэл чулуун зэвсгийн үзмэрүүд дэлгэгдэж сурталчилагдаж үзэгч олны хүлээсэн ажиллагаа болсон.

Аймгийн хүүхдийн урлагийн бага наадамд дунд сургуультай хамтран замын зардалд /хамтарсан/ 38 000 мянган төгрөгийг



байгууллагаас гаргасан.

Соёлын төв нь уртын дууны хамтлаг, туулийн төрөлд дугуйлангийн 22 сурагчийг бэлтгэж Туулийн



төрөлд 6 сурагч амжилттай оролцож Тэргүүн байр эзэлсэн нь дугуйлан сургалтын үйл ажиллагааны үр дүн юм.

Аймгийн соёлын биет бус өвийн Ардын урлагийн их наадамд авьяастнууд амжилттай оролцож багаараа "ТЭРГҮҮН" байр эзлэсэн. Жүжиг наадмын аман уламжлалын төрөлд СТА

Т.Мөнхцэцгийн найруулсан "Соёлын өвөө дээдлье" зохиомж \хамтлаг\ 1-р байр, Монгол зургийн төрөлд Л.Мөнхбадрахын бүтээл 3-р байр, Мал шинжих төрөлд /Дундговийн гүр адуу бүтээл /Т.Гунгаа 1-р байр, Аялгуут аман уламжлал төрөлд С.Төмөрбат 2-р байр, Мал аж ахуйн тоног хэрэгслийн төрөлд С.Ганболдын бүтээл

3-р байр, Ардын уламжлалт гар урлалын Сийлбэрийн төрөлд Алтхүүгийн бүтээл 1-р байр эзэлж, өндөр амжилт гаргалаа.

Нүүдэлчин монгол-2018 Соёлын биет бус өвийн Улсын их наадамд сумаасаа Аймгийн алдарт уяач Т.Гунгаа, модон сийлбэр урлаач С.Алтхүү, хөгжим, ардын язгуур урлагаар Т.Мөнхцэцэг нар амжилттай оролцож Дундговь аймаг багаар 3-р байр эзлэж нутгийнхаа нэрийг дуурсгалаа.Их наадмаас Т.Мөнхцэцэг, Т.Гунгаа нарыг Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч -аар тодоруулан Батламж “ дурсгалын медаль,. Т.Гунгаа нь МУ-ын ТАА цол тэмдгээр тус тус шагнагдсан. Их наадамд хаврын гэрийг эртний эд хэрэгслэлээр тохижуулах ажлыг Гурван сайхан, Өндөршил, Сайнцагаан , Говь угтаал сумдууд хамтран ажиллаж арын албыг маш сайн гүйцэтгэсэн.